Онцгой байдлын ерөнхий газрын ОБЕГ/201901002 дугаар бүхий тендерийн үнэлгээний хорооны 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн хурлаар 100 хувийн саналтайгаар "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 29, 40, 43 дугаар заалтын дагуу дээрх **"хамгийн сайн"** гэж үнэлэгдсэн тендерийг ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулахыг захиалагч Онцгой байдлын ерөнхий газрын дарга, төсвийн ерөнхий менежерт зөвлөмж болгож байна.

Үнэлгээний хорооны дарга:

Тэргүүн дэд дарга, бригадын генерал Г.АРИУНБУЯН

Гишүүд:

Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын

Хангалт, үйлчилгээний хэлтсийн дарга, хошууч Д.БОЛОРЦЭЦЭГ

Монголын хуульчдын холбооны гишүүн Ч.БАТБАЯР

Барилгын инженерүүдийн холбооны гишүүн Б.БАТМАНЛАЙ

Нарийн бичгийн дарга:

Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын

мэргэжилтэн, ахлах дэслэгч Ц.ОНОН

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Сүлдэт тэргүүн ХХК | Цегейк малгай | 45,000,000 | 40,050,000 | 4,950,000 |
| 4 | Би Энд Би Эс ХХК | Каракул,цегейк захтай, савхин гадартай, салдаг дотортой дээл, савхин мөрдөс | 146,011,000 | 141,362,100 | 4,648,900 |
| 5 | Аяга уул ХХК | Ноосон цамц, албаны цамц /урт, богино ханцуйтай/, хээрийн богино ханцуйтай цамц /захгүй/ | 116,000,000 | 115,977,500 | 22,500 |
| 6 | Бест шүес ХХК | Зуны гутал /эр,эм/, зуны гутал хагас түрийтэй гутал /доторгүй/, өвлийн гутал /богино түрийтэй эм/, өвлийн гутал /хагас түрийтэй/ | 400,500,000 | 400,500,000 | 0 |
| 8 | Мон төв ХХК | Энгийн ажилчдын хувцас /зун/, Энгийн ажилчдын хувцас /өвөл/ | 75,000,000 | 68,100,000 | 6,900,000 |
| 9 | Ти эл ти ХХК | Зөөлөн мөрдөс, саан зүүлт, ёслолын саан бүс, том таван хошуу /шаргал мөнгөлөг/, жижиг таван хошуу /шаргал, мөнгөлөг/, цол ялгах тэмдэг /шаргал, мөнгөлөг/, ахлагч тэмдэг /шаргал, мөнгөлөг/ | 93,739,000 | 89,518,000 | 4,221,000 |
| 10 | Дэвжих бат оргил ХХК | Аврагчийн хувцас /зун/, аврагчийн хувцас /өвөл/ | 150,000,000 | 137,500,000 | 12,500,000 |
| 11 | Саруул-Өргөө Констракшн ХХК | Гал сөнөөгчийн хүн нэг бүрийн хувцас хэрэглэл /барилга байгууламжийн/ | 600,000,000 | 545,000,000 | 55,000,000 |
| 12 | Аяга-Уул ХХК | Ногоон саарал дижитал даавуу /өвөл/, ноосон даавуу, Ногоон саарал дижитал даавуу /зун/, | 306,000,000 | 252,448,000 | 53,552,000 |

## ОБЕГ/201901002 ДУГААР БҮХИЙ ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБАНД ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ ХУДАЛДАН АВАХ ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот | № 1 | 2019.04.18

Монгол Улсын Шадар сайдын тушаалаар батлагдсан "Худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу "Онцгой байдлын албанд хувцас хэрэглэл худалдан авах" тендерийн урилгыг 2019 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын www.tender.gov.mn цахим хуудас "Зууны мэдээ" сонин, Онцгой байдлын ерөнхий газрын цахим хуудсанд зарласан.

Тендерийн урилгад заасны дагуу 2019 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 10 цаг 50 минутанд тендерийг цахимаар нээсэн ба ОБЕГ/201901002 тоот "Онцгой байдлын албанд хувцас хэрэгсэл худалдан авах" тендерийн 11 багцад нийт 28 аж ахуйн нэгж санал ирүүлсэн байна.

Хурал тендерийн үнэлгээний хорооны дарга, бригадын генерал Г.Ариунбуян, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын Хангалт, үйлчилгээний хэлтсийн дарга Д.Болорцэцэг, Монголын хуульчдын холбооны гишүүн Ч.Батбаяр, Барилгын инженерүүдийн холбооны гишүүн Б.Батманлай, Санхүү, хангалт, хөрөнгө оруулалтын газрын Хангалт үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн, ахлах дэслэгч Ц.Онон нар тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг нээж, тендерт оролцогчдын ирүүлсэн үнийн санал, банкны баталгааг аж ахуйн нэгж тус бүрээр зарлан тэмдэглэл үйлдэж, тендерт оролцогчдоор гарын үсэг зуруулж баталгаажуулсан.

Тендерийн үнэлгээний хороо нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль", Сангийн сайдын 2007 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 81 дүгээр тушаалаар батлагдсан "Үнэлгээний заавар", ОБЕГ/201901002 дугаар бүхий тендерийн баримт бичгийг мөрдлөг болгон 2019 оны 03 дугаар сарын 25-наас 2018 оны 04 дугаар сарын 17-ны өдрүүдийн хооронд тендерийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн болно.

Тендерт оролцогчдын тендерт ирүүлсэн тендерийн материалын иж бүрдэл, санхүүгийн чадавхи, техникийн тодорхойлолтыг хянан үзэх шатанд нэг бүрчлэн шалгаж, харьцуулах үнийг тогтоон, ирүүлсэн загварын чанар байдлын талаар хурлаар хэлэлцэв. Тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн олонхийн саналаар дараах тендерүүдийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж дүгнэж байна. Үүнд:

| Багц | Нэр | Багцын нэр | Төсөвт өртөг | Ирүүлсэн үнийн санал | Хэмнэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Эко сервис ХХК | Каракуль арьс | 38,000,000 | 37,400,000 | 600,000 |

**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ:** ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Т.БАДРАЛ

**НИЙЛҮҮЛЭГЧ:** "ЭКО СЕРВИС" ХХК-ИЙН ЗАХИРАЛ Ч. СОНОМДАВГА

## ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ

Дугаар № ОБЕГ/201901002-1

2019 оны 04 дүгээр сарын 30 | Улаанбаатар хот

Нэг талаас Онцгой байдлын ерөнхий газар, түүнийг төлөөлж Хангалт үйлчилгээний хэлтсийн дарга, хошууч Д.Болорцэцэг /Цаашид "Захиалагч" гэх/, нөгөө талаас "Эко сервис" ХХК, түүнийг төлөөлж менежер М.Мягмарсүрэн /Цаашид "Нийлүүлэгч" гэх, хамтад нь "Талууд" гэх/ нар зүйлийг харилцан тохиролцож, 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ цаашид "Гэрээ" гэх) байгуулав.

1. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай", Монгол Улсын Иргэний болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь "Онцгой байдлын албанд хувцас хэрэглэл худалдан авах" тендерийн 1 дүгээр багцад заасан "Каракуль арьс"-г 37,400,000 /гучин долоон сая дөрвөн зуун мянга/ төгрөгөөр нийлүүлэхээр ирүүлсэн Нийлүүлэгчийн саналыг энэхүү гэрээгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Гэрээний дүн 37,400,000 /гучин долоон сая дөрвөн зуун мянга/ төгрөг байх ба Онцгой байдлын ерөнхий газрын урсгал зардлаар санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь барааг 2019 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор нийлүүлж, Захиалагч талд хүлээлгэн өгнө.
5. Дор дурьдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно. Үүнд:
   - 5.1 Гэрээний ерөнхий нөхцөл
   - 5.2 Гэрээний тусгай нөхцөл
   - 5.3 Нийлүүлэх барааны техникийн тодорхойлолт
   - 5.4 Үнийн хуваарь
   - 5.5 Бараа нийлүүлэлтийн хуваарь
   - 5.6 Гүйцэтгэлийн баталгаа

   Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх Талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энэхүү гэрээний 4-р хавсралтад заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр Нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар Талууд бичгээр буюу шуудан, цахилгаан холбоо болон факсаар харилцана.
9. Захиалагчийг төлөөлөн худалдан авах ажиллагаанд оролцож байгаа төрийн албан хаагч болон тендерт оролцогч буюу гэрээ хэрэгжүүлэгч бүр худалдан авах ажиллагаанд оролцох, худалдан авах гэрээг хэрэгжүүлэхдээ ёс суртахууны өндөр хэм хэмжээг сахин биелүүлэх, сонирхлын зөрчилгүй байна. Зөрчил үүссэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу арга хэмжээ авна.